

БАТЛАВ: МӨНХХАЙРХАН СУМЫН

ЗАСАГ ДАРГА

Б.БАТБОЛД

Огноо: 2020 оны 02 сар 28 өдөр

**ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ЕБС-ИЙН ДОТУУР БАЙРАНД МАХ, СҮҮ, ЦАГААН ИДЭЭ  
ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалтын нэр: ЕБС-д мах, сүү, цагаан идээ нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг  
сонгон шалгаруулах

Тендерийн дугаар: ХОАМХСЗДТГ-2020-04

## Нэг.ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020-02-28

Тендер шалгаруулалтын нэр: ЕБС-д мах, сүү, цагаан идээ нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: ХОАМХСЗДТГ-2020-04

Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын төсөв

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос "ЕБС-д мах, сүү, цагаан идээ нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" худалдан авалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендер шалгаруулалт цахим хэлбэрээр явагдана. Үнийн санал ирүүлэх хүнсний зүйлийн техникийн тодорхойлолт, худалдан авах тоо хэмжээ болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 03 -р сарын 19 -ний өдрийн 14 цаг 00 минут-с өмнө цахим системээр хүлээн авна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 -р сарын 19-ний өдрийн 14 цаг 30 минут -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийн талаар доорх утсаар холбоо барьж болно.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын ЗДТГ-ын 211 тоот өрөө

Утас: , Факс: 95119855

Имэйл хаяг: edavaa\_e@yahoo.com

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ-д* заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	1. Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан. 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт 4. Татварын байгууллагын тодорхойлолт 5. Харилцагч банкны тодорхойлолт 6. Үйл ажиллагааны танилцуулга, туршлага 7. Ижил төстэй ажил гүйцэтгэж байсан ажлын үзүүлэлт /Сүүлийн 1-2 жил/
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Мөнххайрхан сумын ЗДТГ Өрөөний дугаар: ЗДТГазар, 211 тоот өрөө Огноо: 2020 оны 03 сарын 19-ний өдөр Цаг: Улаанбаатарын цагаар 14 цаг, Орон нутгийн цагаар 13 цаг
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: ЗДТГазар, 211 тоот өрөө  Огноо: 2020 оны 03 сарын 19-ний өдөр  Цаг: Улаанбаатарын цагаар 14 цаг 30 минут, Орон нутгийн цагаар 13 цаг, 30 минут
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

№	Хүнсний нэр төрөл	Техникийн тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Хонины мах	Малын гарал үүслийн бичигтэй, хүүхдийн хоолны хэрэгцээнд нийлүүлж буй малын махыг	кг	2300
2	Ямааны мах	эрүүл ахуйн шинжилгээнд хамруулсан, хадгалалт, хамгаалалт болон чанарын бусад шаардлагуудыг хангасан байна. Үүнд: ямааны мах 14 кг-аас, хонины мах 17 кг-аас, үхрийн 120 кг-аас доошгүй жинтэй байна.	кг	1660
3	Үхрийн мах	Хүүхдийн өсөлт бойжилт, хоолны илчлэг калорилаг, эрүүл ахуйн шаардлага хангах үүднээс хонь ямааны туранхай мах, бярууны мах, гэмтэж бэртсэн малын мах авахгүй болохыг анхаарах	кг	500
4	Цувдай	Хүүхдийн өсөлт бойжилт, хоолны илчлэг калорилаг, эрүүл ахуйн шаардлага хангах үүднээс хонь ямааны туранхай мах, бярууны мах, гэмтэж бэртсэн малын мах авахгүй болохыг анхаарах	кг	200
5	Сүү	Малын гарал үүслийн бичигтэй, хүүхдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлж буй сүү, цагаан идээ нь эрүүл ахуйн шинжилгээнд хамруулсан, малын гаралтай, хадгалалт, хамгаалалт болон чанарын бусад шаардлагуудыг хангасан байна. Үүнд: 1. Сүү нь малын эмчийн бичигтэй	л	300
6	Тараг	эрүүл суурийн малаас саасан сүү байна. Дулааны улиралд шингэнээр нь, хүйтний улиралд зөв технологиор бэлтгэж хөлдөөсөн байдлаар хүлээн авна. Хадгалалт хамгаалалтын горимыг хангасан, хэсэглэн хэрэглэх боломжтой байдлаар савласан байна.	л	198
7	Боз	2. Тараг нь эрүүл суурийн малын сүүгээр бүрж, зөв технологиор бэлтгэгдсэн, гашлаагүй байна. 3. Бозыг шар усыг нь сайн шүүсэн, өтгөн байдлаар бэлтгэсэн байна. Эрүүл ахуйн шаарлагад нийцсэн хэсэглэн хэрэглэх боломжтой нөхцөлөөр савласан байна.	кг	250
		<b>НИЙТ ДҮН</b>		

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

ЕБС-ИЙН ЗАХИРАЛ

НЯРАВ

Б.БАТЗАЯА

Г.БЯМБАА

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Мах, сүү, цагаан идээ	ТББ-т зааснаар	ТББ-т зааснаар	-	Ховд аймгийн Мөнххайрхан сумын ЕБС	2020.03.13	2020.12.31	

Тав. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхой лолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Хэмж их нэгж	Нэгж ийн үнэ	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд үнэ
Мах, сүү, цагаан идээ /г.м/							
<b>Нийт дүн</b>							

Баталгаат засварын хугацаа:

- Санал болгож буй бусад нөхцөл  
Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг

## НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				



## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч машинаа хүлээн аваад төлбөрийн нэхэмжлэх ирснээс хойш 10 хоногийн дотор үнийг нь төлнө.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Сумын Засаг дарга Б.Батболд захиалагч байгууллагаас гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Хүнсний бүтээгдэхүүн учир бүтээгдэхүүн тус бүрийн чанарын баталгаа нь үйлдвэрийн хугацаатай байна.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн . . . . хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,02]**
- Алдангийн нийт дүн: **[0,1]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ  
БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

**[Төндөр шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Төндөр шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]